Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго 1: Сэтгэцийн эрүүл мэндийн хууль эрх зүйн орчин, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах | | | | | | | |
| 1.1 | ЗГҮАХ 2.3.1.2.390 “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна. | | “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан төсөл | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийх чиглэлээр судалгаа хийгдэж дээд шатны байгууллагад хүргэгдсэн. | “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн байна. | ЭМСайдын 2025 оны 1-р сарын 29-ны өдрийн А/24 тоот тушаалаар “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай“ хуулийн үр нөлөөний үнэлгээ хийсэн. Үнэлгээнд үндэслэн “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн байна. | 100% |
| 1.2 | СЭМЦАХТ 1.3 СЭМСогтуурууулах ундааны хэрэглээг бууруулах ДЭМБ-аас "Аюулгүй" арга хэмжээ санаачилгыг дэмжих, нутагшуулах төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. | | "Аюулгүй" арга хэмжээний тойм судалгааны тайлан, боловсруулсан төлөвлөгөө | ДЭМБ-ын "Аюулгүй" арга хэмжээний нөхцөл байдлын тойм судалгааг 2023 оны байдлаар хийж гүйцэтгэсэн. | "Аюулгүй" арга хэмжээний тойм судалгааг дахин үнэлж, төлөвлөгөөг боловсруулж ЭМЯ-д хүргүүлнэ. | ДЭМБ-н "Аюулгүй" зөвлөмжийн дагуу Монгол улс дахь архи согтууруулах ундааны эсрэг бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдалд үнэлгээ хийсэн, 2026 оны 04-р сарын 16-17 ны өдрүүдэд, 30 байгууллагын 80 хүнийг хамруулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж. "Аюулгүй" үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. | 75% |
| 1.3 | Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны | | Боловсруулсан төслийн төлөвлөгөө | “Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө | Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг | Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг ЭМЯ-ны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг боловсруулсан байна | | | боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. | боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна. | | |
| 1.4 | СЭМЦАХТ 1.7 Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалж, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна. | | Боловсруулсан төслийн төлөвлөгөө | Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалж, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. | Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалж, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг бусад байгууллагуудаас саналыг авч тусган, ЭМЯ-д хүлээлгэн өгнө. | "Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалж, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх (2026-2029 он) төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч тусган, ЭМЯ-д хүлээлгэн өгсөн. | 100% |
| 1.5 | Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг, СЭМЦАХТ 2 Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээний журмын төслийг боловсруулна. | | Боловсруулсан журмын төсөл | Салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан | Амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх маягтыг батлуулж, мэдээллийн сан үүсгэх журмын төслийг боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн байна. | Салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулж, Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи, мансууруулах бодис хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай төслийн эхний хувилбарыг боловсруулж, ЭМЯ-д хүлээлгэн өгсөн. | 100% |
| 1.6 | ЗГҮАХ 2.3.1.2.391, СЭМЦАХТ Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих ажлын хэсэгт санал оруулна. | | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төсөл | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна. | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт хамтран ажиллаж, хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна. | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих ажлын хэсэгт санал оруулсан байна. | 100% |
| 1.7 | ЗГҮАХ 4.4.1.9.1250 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд | | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төсөл | 2025 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсэгт санал оруулна | | | шинэчилсэн найруулгын боловсруулсан төсөл | хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт хамтран ажиллаж, хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна | боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсэгт санал оруулсан байна. | |
| Зорилго 2: Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх нутагшуудах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй, эрсдэлгүй ээлтэй орчин бүрдүүлэх | | | | | | | |
| 2.1 | Олон улсын өвчний 11 дүгээр ангиллын сэтгэцийн эмгэг судлалын бүлгийн хэсгийг орчуулж, боловсруулна. | ЭМДСан, ОУБ | Олон улсын өвчний 11 дүгээр ангиллын сэтгэцийн эмгэг судлалын орчуулгын төсөл | Олон улсын өвчний 11 дүгээр ангиллын сэтгэцийн эмгэг судлалын бүлгийн орчуулах ажлын хэсэг байгуулагдсан. | Олон улсын өвчний 11 дүгээр ангиллын сэтгэцийн эмгэг судлалын бүлгийг орчуулж, хянасан байна. | Олон улсын өвчний 11-р ангиллын орчуулгын ажил дуусч, хянах ажлыг явуулж байна. | 50% |
| 2.2 | ЭМС-ын А/147 тоот тушаал хэрэгжилт, ХӨҮҮСЭМХТ 4.3.1.1 ӨЭМТ, СЭМТ-н эмч мэргэжилтнүүдэд зориулсан аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлгийн сорилын (M-CHAT-R) арга зүйг боловсруулж, туршилт судалгаа хийнэ. | | Аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлгийн сорилын боловсруулсан арга зүйн төсөл, судалгааны үр дүн | Аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлгийн сорилыг орчуулсан | ӨЭМТ, СЭМТ-н эмч мэргэжилтнүүдэд зориулсан аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлгийн сорилын (M-CHAT-R) арга зүйг боловсруулж, СЭМҮТ-н Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, туршилт судалгааг эхлүүлсэн байна. | Баянзүрх Дүүргийн Өрхийн Эрүүл Мэндийн Төвийн нийт 32 эмч нарт “Аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлэх” сорилыг ашиглах туршилт судалгааны арга зүйн сургалтыг 2026 оны 5 сарын 19-ний өдөр зохион байгуулсан. | 40% |
| 2.3 | ХБӨ төлөвлөгөө 6.5 Архи, тамхины оношилгоо, эмчилгээнд шаардагдах ДЭМБ-ын зөвлөсөн зайлшгүй шаардлагатай эмийн бүртгэлд санал оруулна. | Орон нутгийн төсөв | Зайлшгүй шаардлагатай эмийн 11-р жагсаалтанд орсон эмийн жагсаалт, санал | Зайлшгүй шаардлагатай эмийн 10-р жагсаалт | Зайлшгүй шаардлагатай эмийн 11-р жагсаалтад “дисульфирам, акампросат, никотин орлуулагч наалт, налтрексон, варениклин, бупропион гидрохлорид” эмүүдийг зайлшгүй | Зайлшгүй шаардлагатай эмийн 11-р жагсаалтад дисульфирам, акампросат, никотин орлуулагч наалт, налтрексон, варениклин, бупропион гидрохлорид зэрэг эмүүдийг оруулахаар санал хүргүүлсэн боловч тухайн жагсаалтад зөвхөн налтрексон эм орсон байна. | 20% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай эмийн жагсаалтад оруулахаар санал хүргүүлсэн байна. | | |
| 2.4 | МЭСНБХБЭТҮХ 2.1 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний заавар (9 бүлэг)-ыг боловсруулж ЭМЯ-д хүргүүлнэ. | | Батлагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний заавар | Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний заавар (9 бүлэг)-ыг ЭМЯ-ны удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний зааврыг (9 бүлэг) боловсруулж, ЭМЯ-ны дэргэдэх Сэтгэцийн мэргэжлийн салбар зөвлөлөөр хянуулах үе шатандаа явж байна. | 75% |
| 2.5 | ЭМЯ, ЭМХТ-тэй хамтран "Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй"-н төгсөлтийн дараах мэргэшүүлэх 4 сарын сургалтыг жилд 1 удаа зохион явуулах | | Хэлэлцүүлэгт хамрагдсан тоо | Хаврын элсэлтийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна. | Чанартай аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлж эмчлүүлэгчдийн засрал сайжрал нэмэгдэнэ. | Төгсөлтийн дараах мэргэшүүлэх "Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй"-н 4-н сарын сургалт, 2026 онд 04 дүгээр сарын 01-нээс 07 сарын 03 хүртэл зохион байгуулагдаж байна. Нийт 11 сувилагч суралцаж байгаагаас СЭМҮТ-ээс 8 сувилагч, орон нутгаас 2 сувилагч, Оточ маарамба сургуулиас 1 сувилагч тус тус суралцаж байна. | 75% |
| 2.6 | "Гэр бүл хөдөлмөр нийгэм хамгааллын яам, АШУҮИС-ийн харъяа Сувилагчийн сургуультай хамтран төвийн 60 асрагчийг "Сувилагчийн туслах" –ын сургалтад хамруулж, Чадамжийн гэрчилгээ олгуулах | | Хамтран ажиллаж зөвлөн, дэмжиж ажилласан тоо | Сувилагчийн туслах бэлтгэх сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж байна. | Сувилахуйн тусламж үйлчилгээнд тэгш хүртээмжтэй үзүүлнэ. | АШУҮИС-ын Сувилахуйн сургуулийн суурь сувилахуйн тэнхимтай гэрээ байгуулан "Сувилагчийн туслах "-ын 3 сарын сургалтад 60 ажилтанг 2 үе шаттайгаар сургалт зохион байгуулсанаас 1 үеийн 25 ажилтан шалгалтаа амжилттай өгөн төгслөө. 2 үеийн 25 ажилтан одоо суралцаж байна. | 75% |
| 2.7 | Сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний 5 эмнэл зүйн заавар батлуулах /БСТ 1.2.1/ | Үйл ажиллага аны орлогоос | Батлуулсан заавар | Сэтгэц зан үйлийн эмгэгийн оношлогоо эмчилгээний үндэсний стандарт ашиглаж байсан. Оношилгоо эмчилгээний эмнэл зүйн заавар шинээр | Сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээнд ашиглах эмнэл зүйн зааврын тоо нэмэгдэнэ. | 2026 оны эхний хагас жилийн байдлаар F10-Архины шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэгийн оношилгоо эмчилгээний зааврыг боловсруулж дуусаад, Сэтгэцийн мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцэн холбогдох засваруудыг хийсэн. Зааврын төслийг | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлуулах шаардлагатай. | | Эрүүл мэндийн яаманд хүргүүлж батлуулахаар бэлтгэл ажлыг хийж байна. | |
| 2.8 | Сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчтэй ажиллаж байгаа эмч, ажилчдын ажлын байрны ачааллын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Үйл ажиллагааны орлогоос | Үнэлгээний тайлан | Эмч, ажилчдын ажлын байрны ачааллын үнэлгээ хийгдэж байгаагүй. | Эмч, ажилчдын ажлын байрны бодит ачааллыг үнэлэн гаргасан байна. Ачааллын үнэлгээнд суурилсан хүний нөөц, бүтэц үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага тодорхой гарна. | Эмч, ажилчдын ажлын байрны бодит ачааллыг үнэлэн гаргасан байна. Ачааллын үнэлгээнд суурилсан хүний нөөц, бүтэц үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага тодорхой гарна. | 75% |
| 2.9 | Сэтгэцийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинээр боловсруулж батлуулах ажлыг эхлүүлэх | Үйл ажиллагааны орлогоос | Ажлын хэсэг байгуулагдсан, стандартын төсөл гарсан байна. | Төрөлжсөн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартаар ажиллаж байгаа нь сэтгэцийн эмнэлгийн үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байгаа нь тусдаа бие даасан стандарттай байх шаардлага үүсч байна. | Сэтгэцийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төсөл боловсруулагдсан явцын хэлэлцүүлэг хийгдсэн байна. | Сэтгэцийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төсөл боловсруулагдсан явцын хэлэлцүүлэг хийгдсэн байна. | 75% |
| 2.10 | Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган бэлтгэл хангаж ажиллах | Үйл ажиллагааны орлогоос | Бэлтгэл ажлын төлөвлөгөө, тайлан | 2024.03.23-2027.03.23-ны өдрийг хүртэл магадлан итгэмжлэлийн хугацаа 3 жилээр сунгагдсан, 2027 оны 03 сард магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдана. | Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган бэлтгэл хангагдсан байна. | Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/27 дугаар тушаалын дагуу ЭМХТ-өөс 2026 оны 04 сард магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээг хийгдсэний дагуу ЭМХТ-д Магадлан итгэмжлэлийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2026 оны 04 сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд 3 чиглэлээр 24 ажил төлөвлөн хэрэгжилтийг дүгнэн тайлан хүргүүлсэн | 75% |
| 2.11 | Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээг өргөжүүлэн, | | Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээнд | Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ болон клиникийн уялдааг | Гимнастик хийх засал, биеийн тамир эмчилгээ, эмнэлгийн гадна | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.6 дахь заалт болон холбогдох журам, стандартын дагуу сэтгэц-нийгмийн | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг тогтмолжуулах /БСТ 2.2.3/ | | хамрагдсан хүний тоо | сайжруулах шаардлага байгаа | орчинд идэвхжүүлэх, тоглоом эмчилгээ, дуу хөгжим эмчилгээ, үзвэр эмчилгээ, ном эмчилгээ, гар урлал (давс, шүр, наамал), зураг эмчилгээ, ном эмчилгээ, хөдөлмөр эмчилгээ, өөрийгөө удирдах дадалд сургах | сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>СЭМҮТ-ийн захирлын 2026 оны А/01 тушаалаар Сэтгэц-нийгмийн сэргээн засах эмчилгээний тасаг нь 10 орон тоотойгоор шинэчлэгдэн зохион байгуулагдсан.<br>Тайлант хугацаанд нийт 2145 хүнд 1359 удаагийн бүлгийн болон ганцаарчилсан үйл ажиллагааг явуулсан. Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээг биеийн тамирын (гимнастик, идэвхтэй хөдөлгөөнт дасгал, спорт тоглоом, шугаман болон монгол бүжиг), урлаг эмчилгээ (дуу, хөгжим, үзвэр, гар урлал, зураг), нийгэмшүүлэх болон чөлөөт цагийн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан. | |
| 2.12 | Сэтгэл зүйн оношилгооны практикт шинээр 1 арга, аргачлалыг нэвтрүүлэх /БСТ 2.2.2/ | | Оношилгоонд хамрагдсан хүний тоо | Тус төвд уг оношилгоо хийгдэж байгаагүй | -Танока-Бине сорилыг оношилгоонд нэвтрүүлэх шийдвэр гарч, хэрэгжүүлэх мэргэжилтний болон зохион байгуулалтын бэлтгэл хийгдсэн байна. | МУБИС- руу хамтран ажиллах хүсэлтийг албан бичгээр илгээхээр төлөвлөж тус бичгийг Эмнэлзүйн хариуцсан захирлаар хянуулахаар өгсөн байна. | 50% |
| 2.13 | Шинэ сувилагч, туслах сувилагчийг чадавхижуулах сургалтыг сар бүр зохион байгуулах | | Сургалтад хамрагдсан тоо | 2025 онд чиглүүлэх сургалтын хүрээнд нийт 17 сувилагч, туслах сувилагч хамрагдсан байна. | Шинэ сувилагч, туслах сувилагчийг чадавхижуулах суралтанд 20-оос доошгүй сувилагч, туслах сувилагчийг хамруулна. | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд ажиллаж буй Шинэ сувилагч, 2026.04.16-ны өдөр Сувилахуйн Мэргэжлийн Холбооноос “Сувилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт 2 багц цагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.<br>Сургалтад 61 ахлах сувилагч, сувилагч нар хамрагдав. | 75% |
| Зорилт 3: Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, нийгэм хамт олны оролцоог нэмэгдүүлэн, сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүн, хамт олны мэдлэг, чадварыг дээшлүүлэх | | | | | | | |
| 3.1 | СЭМЦАХТ 2.12 Сэтгэцийн эрүүл | ЭМДС, ОУБ | Эрдэм шинжилгээний | 2025 онд Олон улсын эрдэм шинжилгээний | Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр | "Сэтгэцийн эрүүл мэнд 2026" Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2026 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна | | хурлын тайлан, хуралд ирүүлсэн итгэлийн тоо | хурлыг нийт 400 гаруй мэргэжилтнүүдийг хамруулж, 50 илтгэл хүлээн авсан. | эрдэм шинжилгээний хурал, зохион байгуулсан байна. | оны 09 сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. | |
| 3.2 | СЭМЦАХТ 2.18 Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нөлөөллийн ажлуудыг цахим орчинд тогтмол зохион байгуулна | - | СЭМҮТ-н веб хуудас, Facebook, youtube-д оруулсан контентын тоо | СЭМҮТ-н веб хуудас, Facebook, youtube хуудсанд сар бүр тогтмол 1 контент оруулж байсан. | Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нөлөөллийн ажлуудыг СЭМҮТ-н веб хуудас, Facebook, youtube хуудсанд сар бүр тогтмол 2 контент оруулна. | Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нийт 12 контентийг хүргэсэн байна. | 100% |
| 3.3 | Дэлхийн өдрүүд (архи, тамхи, мансууруулах бодис, амиа хорлолт, сэтгэцийн эрүүл мэнд)-ийг тохиолдуулан нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | ОУБ | Нөлөөллийн ажлын батлагдсан төлөвлөгөө, ажлын тайлан | Жил бүр тодорхой уриа дор зохион байгуулдаг. | Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулна. | 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Тамхины эсрэг өдөр – Таны нэгдэх өдөр” уриатай нийгмийн арт хөдөлгөөн, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээг Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, НЭМҮТ болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тамхины хэрэглээний хор нөлөө, дам тамхидалтын эрсдэлийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тамхины хяналтын бодлого, эрх зүйн орчныг дэмжихэд чиглэв. | 50% |
| 3.4 | А147 тоот тушаал хэрэгжилт, ХӨҮСЭМХДТ 4.1.1 Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн тулгамдсан асуудал, хүүхдийн сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгэл зүйч, эмч, нийгмийн | | Сургалтын хөтөлбөр, сургалтын тайлан | Сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. | Хүүхэд өсвөр үеийн сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтанд зориулсан хүүхдийн сэтгэцийн тулгамдсан асуудал, хүүхдийн сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх | 2026.05.27-ны өдөр Өсвөр үеийнхний амиа хорлолт, сэтгэл гутрал, зан үйлийн өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт ЕБС-н 100 эрүүл мэндийн багш, ажилтнуудад онлайнаар сургалтыг зохион байгуулсан.<br>2026.06.18-ны өдөр Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн түгээмэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилтанд зориулсан сургалт зохион байгуулна. | | | | чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулсан байна. | тохиолдох эмгэгийн оношилгоо зөвлөгөө сэдвээр 9 дүүргийн нийт 60 мэргэжилтэн, (нийгмийн ажилтан, хүүхэд өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч) нийт 60 мэргэжилтэнд сургалтыг зохион байгуулсан. | |
| 3.5 | ЗГҮАХ-4.1.1.4.1029 Эрэгтэйчүүдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх,стрессийг даван туулах, амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх заавар гарган батлуулж, холбогдох чиглэлийн сургалт, зөвлөгөө өгнө | | Боловсруулсан зааврын төсөл, сургалт тоо, хамрагдсан хүний тоо | Сэтгэц, донтолт, мэдрэлийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний заавар боловсруулсан ба амиа хорлохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ агуулгыг тусгасан. | Эрэгтэйчүүдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх, стрессийг даван туулах, амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх зааврыг боловсруулж, зааврын дагуу чиглэлийн сургалт, зохион байгуулж, зөвлөгөө өгнө. . | - Зэвсэгт хүчний 311, 326, 119, 120 -р ангийн байлдагч болон алба хаагч нарт, Дотоодын цэргийн 05-р анги, 810, 805-р ангийн хугацаат цэргүүд болон алба хаагч нарт “Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ерөнхий ойлголт” сэдвээр сургалт орсон ба сургалтад 1,126 хугацаат цэрэг, 315 байнгын бүрэлдэхүүн оролцож, ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөөг нийт 14 хугацаат цэрэг, 12 алба хаагчид өгсөн.<br>- Хууль сахиулах байгууллагын нийт 210 алба хаагчид "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт, стресс менежмент" болон "Архинд донтох эмгэг" сэдвээр мэдээлэл өгсөн.<br>- Амиа хорлох бодол санаа, үйлдэл хийсэн эмчлүүлэгчдэд үзүүлэх сэтгэлзүйн түргэн тусламж, менежмент болон бусад сэтгэцийн яаралтай түргэн тусламж” сэдэвт сургалтыг “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн нийт 152 эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан. | 70% |
| 3.6 | ХБӨ 4.4<br>Архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийг эмчлэх, зөвлөгөө өгөх, эрүүл мэнд- сэтгэц-нийгмийн сэргээн засах арга зүйд аймаг, дүүргийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг сургах сургалт зохион | ЭМДС Орон нутгийн төсөв, ДЭМБ | Аймаг, дүүргийн сум, өрхийн ЭМТ-ийн "Архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийг эмчлэх, зөвлөгөө өгөх арга зүйн сургалт"-д хамрагдсан тоо | Сэтгэц, донтолт, мэдрэлийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний сургалтад “Архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийг эмчлэх, зөвлөгөө өгөх, эрүүл мэнд- сэтгэц-нийгмийн сэргээн засах” агуулгыг тусгасан. | Сургалтад 50 мэргэжилтнийг хамруулна. | Архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийг эмчлэх, зөвлөгөө өгөх, эрүүл мэнд- сэтгэц-нийгмийн сэргээн засах арга зүйд аймаг, дүүргийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийт 55 эмч нарт (Дундьговь, Өмнөговь) сургалтыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, чадавхжуулах | | | | | | |
| 3.7 | МЭСНБХБЭТҮХ 4.3 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, электрон болон утаат тамхины хор уршиг, эмийн буруу болон хэтрүүлэн хэрэглэхийн хор уршиг, сэргийлэх арга замын талаар зөвлөгөө, мэдээлэл өгнө. | ОУБ | 1800-2000 утас, сургалт, зөвлөгөө, мэдээллийн тоо | 2025 онд 1800-2000 утасны зөвлөгөө<br>-архины асуудал - 28 хувь<br>-мансуурал -1 хувь авсан. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, электрон болон утаат тамхины хор уршиг, эмийн буруу болон хэтрүүлэн хэрэглэхийн хор уршиг, сэргийлэх арга замын талаар зөвлөгөө, мэдээлэл ЕБС-ийн сурагчдад 2 удаа, их дээд сургуулийн оюутнуудад 2 удаа, төрийн алба хаагчдад 2 удаа өгсөн байна. | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, салбар нэгжид ажиллаж буй 37 сэтгэл зүйчид “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэц, зан төрхийн эмгэгийн үед илрэх шинж тэмдэгүүд ба анхан шатны тусламж, үйлчилгээ” сэдвээр сургалт явуулсан.<br>- “Мансууруулах бодисын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг” сэдвээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн 35 алба хаагчид мэдээлэл өгсөн.<br>- НТТТ-ийн нийт 152 эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд сургалтад хамрагдсан. Уг сургалтын хүрээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэц, зан төрхийн эмгэгийн үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ” сэдвээр сургалт явуулсан.<br>- 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Тамхины эсрэг өдөр – Таны нэгдэх өдөр” уриатай нийгмийн арт хөдөлгөөн, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.<br>- 2026 оны эхний хагас жилийн байдлаар 18002000 мэдээллийн утсаар архи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон мөрийтэй тоглоомонд донтох эмгэгтэй холбоотой нийт 422 дуудлага хүлээн авч утсаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.<br>Үүнээс:<br>1. Насанд хүрэгчид:<br>• Архины хэрэглээ – 363<br>• Тамхинд донтох эмгэг – 3<br>• Мансууруулах бодисын хэрэглээ – 20<br>• Мөрийтэй тоглоомонд донтох эмгэг – 31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Хүүхэд:<br>• Мансууруулах бодисын хэрэглээ /ахуйн хэрэглээний газ/ – 5 байв. | |
| 3.9 | ДЭМБ-ын сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг өргөжүүлэх, сургалт зохион байгуулах | ОУБ | Сургалтын тайлан | 2022-2025 онд 16 аймаг, 5 дүүрэгт зохион байгуулсан. | ДЭМБ-ын сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | Энэ ажлын хүрээнд 2022-2025 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Багануур, Налайх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг, Чингэлтэй хөдөө орон нутгаас Хэнтий, Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Дорноговь, Говьсүмбэр, Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий зэрэг нийт 6 дүүрэг, 17 аймгийн 899 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ДЭМБ-ын сэтгэц, мэдрэл, донтох эмгэгийн (СМД) заавар буюу mhGAP анхан болон давтан (Хөвсгөл аймаг ) багц сургалтад тус тус хамруулсан. 2026 онд Өмнөговь, Дундговь аймагт зохион байгуулсан. | 100% |
| Зорилт 4: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулна | | | | | | | |
| 4.1 | СЭМЦАХТ....<br>Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгааны арга аргачлал боловсруулж батлуулах /БСТ 1.2.1.5/ | ОУБ | Батлагдсан судалгааны арга аргачлал | Сэтгэцийн эмгэгийг оношлоход олон улсад түгээмэл хэрэглэдэг "Мэдрэл-сэтгэцийн эмгэгийг оношлох MINI ярилцлага асуумж"-ийн хүчин төгөлдөр байдлыг үнэлсэн. | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгааны арга аргачлал боловсруулж батлуулсан байна. | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгааны ажлын удирдамж болон төсвийг боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү мөн СЭМҮТ-н Эрдмийн зөвлөлийн хурлаар, арга аргачлалыг батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 75% |
| 4.2 | СЭМЦАХТ<br>Мэдээлэл технологийн апп, вэб хөтөч, интернет орчинд суурилсан согтууруулах ундааны хэрэглээний түвшинг тодорхойлох AUDIT сорил (Alcohol Use Disorders Identification Test) -г ашиглах, үнэлэх ур чадварыг эзэмшүүлэх | | Судалгааны тайлан | 2025 онд 466 байгууллагын төлөөлөл болох нийт 825 хүн хамрагдаж, архинд донтох эмгэгээс сэргийлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх, архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх мэдлэгтэй болсон. | AUDIT сорилыг ашиглах, үнэлэх, мэдлэг чадварыг эзэмшүүлэх сургалтын видео бэлтгэн эрүүл мэндийн байгууллагуудад түгээж согтууруулах ундааны хэрэглээний түвшинг | Мэдээлэл технологийн апп,вэб хөтөч, интернет орчинд суурилсан согтууруулах ундааны хэрэглээний түвшинг тодорхойлох AUDIT сорил (Alcohol Use Disorders Identification Test) -г ашиглах, үнэлэх ур чадварыг эзэмшүүлэх сургалтын видео бичлэгийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтыг цахим хэлбэрээр түгээж, согтууруулах ундааны хэрэглээний түвшинг тодорхойлох туршилт судалгаа хийнэ. | | | | тодорхойлох сургалтыг зохион байгуулж, туршилт судалгаа хийнэ. | | |
| 4.3 | Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын газрын харьяа ангиудын албан хаагчид, СЭМҮТ -ийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэнд, ажлын байран дээрх хүчирхийлэл болон стрессийг үнэлэх, эрсдлийг тодорхойлох судалгаа хийнэ. | | Судалгааны тайлан | 2025 онд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, архины хамаарал, мөрийтэй тоглоомонд донтох байдлыг үнэлж тандах судалгааг нийт 1,398 албан хаагчдыг хамруулан хийсэн. | Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа ангиудын албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэнд, ажлын байран дээрх хүчирхийлэл болон стрессийг үнэлж, эрсдлийг тодорхойлсон судалгаа хийсэн байна. | Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа ангиудын албан хаагчдын дунд сэтгэцийн эрүүл мэнд, ажлын байран дээрх хүчирхийлэл болон стрессийг үнэлэх судалгааны ажил хийгдэж байгаа болно. Одоогоор тоон мэдээллийг цуглуулах шатандаа явж байна. | 75% |
| 4.4 | Хүн амын дунд сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэг ба хандлагын түвшинг үнэлэх судалгаа хийнэ. | ОУБ | Судалгааны тайлан | Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг үнэлэх MHKQ /Mental Health Knowledge Questionnaire/ болон хандлагыг үнэлэх CAMI12 /Community Attitudes toward Mental Illness/ асуумжуудын эхний шатны орчуулга хийгдсэн. | Хүн амын дунд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол болон хандлагыг үнэлсэн судалгааны ажил хийгдсэн байна. | Судалгааны ажлын арга аргачлалыг боловсруулж дууссан ба СЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил явагдаж байна. | 75% |
| 4.5 | Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын дагуу боловсруулж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж, чадавхжуулах | ОУБ | Сургалтын хөтөлбөр, сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 2025 онд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн Донтолт судлал, Сэтгэл засал судлал, Шүүхийн сэтгэц судлал, Хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал, Эмнэл зүйн сэтгэл зүй судлал чиглэлээр нийт 50 сэтгэцийн эмч бэлтгэгдсэн. | Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын дагуу боловсруулж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж, 50 эмчийг чадавхжуулсан байна. | 1. Донтолт судлал, сэтгэл засал судлал, шүүхийн сэтгэц судлал, хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал, эмнэл зүйн сэтгэл зүй төрөлжсөн мэргэшлийн чиглэлд 55 эмч суралцаж байна. Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн<br>Хүүхэд, өсвөр үе судлал -4,<br>Шүүхийн сэтгэц судлал-13<br>Донтолт судлал-15<br>Сэтгэл засал судлал-15<br>Эмнэл зүйн сэтгэл зүй судлал-6 нийт 53 эмч суралцаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. “Шүүхийн сэтгэц судлал” мэргэжил дээшлүүлэх сургалт 2026 оны 05 дугаар сарын 25–ны өдрөөс 5 дугаар 30-ны өдрүүдэд ОХУ-ын Эрүүл мэндийн яамны “В.П. Сербскийн нэрэмжит Сэтгэцийн эмгэг, наркологийн үндэсний анагаах ухааны судалгааны төв”-ийн профессор, анагаах ухааны доктор (Ph.D), сэтгэцийн эмч, шүүх сэтгэцийн шинжээч эмч Ирина Николаевна Винникова удирдан явуулж орон нтуаг, СЭМҮТ, ШШЕГ шинжээч дэрэг нийт 40 эмч хамрагдсан. | |
| 4.6 | А147 тоот тушаал хэрэгжилт, ХӨҮСЭМХДТ 4.2 Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл түгшилт болон сэтгэл гутралыг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг RCADS /Revised Children’s Anxiety and Depression Scale/ асуумжийн хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг үнэлэх судалгаа хийнэ. | | Судалгааны тайлан | Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл түгшилт болон сэтгэл гутралыг үнэлдэг RCADS асуумжийн аргачлалыг орчуулж дууссан. | Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл түгшилт болон сэтгэл гутралыг үнэлэх RCADS асуумжийн хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг үнэлсэн судалгааг хийсэн байна. | Судалгааны ажлын арга аргачлалыг боловсруулж дууссан ба СЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил явагдаж байна. | 75% |
| 4.7 | А147 тоот тушаал хэрэгжилт, ХӨҮСЭМХДТ 4.2 Аутизмын хүрээний эмгэгийг оношлоход өргөн хэрэглэгддэг CARS /Childhood Autism Rating Scale/ болон ADOS /Autism Diagnostic Observation Schedule/ асуумжийн хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг үнэлэх судалгаа хийнэ: | | Судалгааны тайлан | Аутизмын хүрээний эмгэгийг оношлоход өргөн хэрэглэгддэг CARS болон ADOS асуумжийн аргачлалуудыг орчуулж дууссан. | Аутизмын хүрээний эмгэгийг оношлоход өргөн хэрэглэгддэг CARS болон ADOS асуумжийн хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг үнэлсэн судалгааг хийсэн байна. | Судалгааны ажлын арга аргачлалыг СЭМҮТ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил явагдаж байна. | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.9 | 21 аймаг, 9 дүүрэг, СЭМҮТ-ийн хяналтад байдаг сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн бүртгэлийг гаргаж, тандалт хийх | | Гаргасан тайлан | Хураангуй тоо мэдээлэл байсан. | 21 аймаг, 9 дүүрэг, СЭМҮТ-ийн хяналтад байдаг сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн бүртгэлийг гаргаж, тандалт хийх | Сэтгэцийн эмгэгээр хяналтанд байдаг буюу 2025 оны ЭМТ-305.1.1 тайланг 2026 оны 2 сард нэгтгэн тайлагнасан. Дээрх үзүүлэлтээс харахад хяналтанд байгаа үйлчлүүлэгчдийн 14089 нь ДЭМТ-д, 7467 нь СЭМҮТ-д, орон нутгийн эмнэлгийн хяналтанд 17834 үйлчлүүлэгч, нийт 14089 үйлчлүүлэгч хяналтанд байна | 100% |
| 4.10 | СЭМҮТ-ийн үйл ажиллагааны үзүүлэлтээр 2021-2025 оны “Сэтгэцийн эрүүл мэндийн үзүүлэлт” эмхэтгэл боловсруулж цахимаар түгээх | | Сэтгэцийн эрүүл мэндийн эмхэтгэл гаргасан байна | 2020-2024 он 5 жилийн үзүүлэлтийн эмхэтгэл хийсэн. | СЭМҮТ-ийн үйл ажиллагааны үзүүлэлтээр 2021-2025 оны үзүүлэлтийн ном гаргаж албан хэрэгцээнд ашиглана. | СЭМҮТ-ийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтээр 2021-2025 оны үзүүлэлтийн номны эмхэтгэлийг бэлтгэж хянуулж дууссан байна. II улиралд цахимаар түгээхээр төлөвлөн ажиллаж байна. | 75% |
| 4.11 | Эрүүл мэндийн сайдын 611 тушаалыг хэрэгжүүлэн сар бүр ЭМХТ - СМАлбанд - 501.1.2 сарын мэдээ<br>- АМ-2 Халдварт өвчин / H-info /<br>- АМ-4 Сүрьеэ/ H-info /<br>- АМ-6 Халдварт бус өвчин/ H-info /<br>- АМ-7 Нас баралт / H-info /<br>- Осол гэмтэл / H-info /<br>- СТ-2 Эмнэлгээс гарагчийн мэдээг / H-info /<br>тоо мэдээ мэдээллэх | | Сарын мэдээ тайлан гаргана. | 2025 онд сар бүр хугацаандаа тайлан мэдээгээ H-info программаар цахимаар илгээсэн. | 2026 онд сар бүр хугацаандаа тайлан мэдээгээ H-info программаар цахимаар илгээнэ. | 2026 оны эхний 5 сарын мэдээг журамд заасан хугацаанд Hinfo-3 болон Hinfo.mn программд шивж, цахимаар илгээж байна.<br>ЭМХТ-өөс үнэлдэг 2025 оны жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр 96,6% үнэлэгдсэн. | 100% |
| 4.12 | Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны тайланг 21 аймаг, 8 дүүргээс хүлээн авч нэгтгэн ЭМХТ-д хүргүүлэх | | Гаргасан тайлан | 2025 онд тайлан гаргасан байна. | 2026 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны улсын тоо үзүүлэлтийг нэгтгэн, гаргана. | Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны тайланг дараа оны 2 сарын 10-ны дотор гаргадаг. 2025 оны тайланг 2026 оны 2 сарын дотор илгээсэн. 2026 оны тайланг 2027 оны 2 сард нэгтгэж илгээнэ | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.13 | Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалыг хэрэгжүүлэн хүлээгдлийн мэдээг сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногт мэдээллэх | | 1.Хэвтүүлэн эмчлэх орны хүлээгдлийн мэдээ гаргасан тоо<br>2.Оношилгооны кабинетын хүлээгдлийн мэдээ гаргасан тоо<br>3.Лаборатори | 2025 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлж байсан. | 2026 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлнэ. | Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалыг хэрэгжүүлэн хүлээгдлийн мэдээг сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногт буюу 2026 оны 6 сарын байдлаар 8 удаа мэдээлсэн байна. | 100% |
| 4.14 | Эмгэг судлалын үндэснйи төвд эмнэлгийн нас баралт мэдээллэх | | Гаргасан тайлан | 2025 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлж байсан. | 2026 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлнэ. | 2026 оны 5 сарын байдлаар 3 нас баралт бүртгэгдсэн ба Эмгэг судлалын үйл ажиллагааны сарын мэдээг тогтмол мэдээлж байна. | 100% |
| 4.15 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлиг "Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу<br>- Архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бодисын хэрэглээ,<br>- Донтох эмгэг, сэтгэц, зан үйлийн эмгэг, оюуны хомсдолын талаарх судалгаа, дүн шинжилгээ хийх | | Гаргасан тайлан | 2025 онд хагас бүтэн жилээр мэдээг цахимаар хүргүүлж байсан. | 2026 онд хагас бүтэн жилээр мэдээг цахимаар хүргүүлнэ. | "Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу - Архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бодисын хэрэглээ,<br>- Донтох эмгэг, сэтгэц, зан үйлийн эмгэг, оюуны хомсдолын хагас жилийн тайланг маягтын дагуу 2026 оны 6 сарын 10-ны өдөр цахимаар илгээсэн. | 100% |
| 4.16 | Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт сар бүр<br>1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай буюу донтох эмгэгтэй иргэдийн бүртгэл судалгаа;<br>2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн | | Гаргасан тайлан | 2025 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлж байсан. | 2026 оны турш сар бүр мэдээг цахимаар хүргүүлнэ. | Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт сар бүр буюу 5 сарын байдлаар 5 удаа доорх мэдээллийг хүргүүлсэн.<br>1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай буюу донтох эмгэгтэй иргэдийн бүртгэл судалгаа;<br>2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн шалтгаантай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалтгаантай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа;<br>3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн шинжээч эмч нарын дүгнэлтийн (хамааралтай, донтой, аюултай хэрэглээтэй эсэх) бүртгэл судалгааг хүргүүлэх | | | | | 3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн шинжээч эмч нарын дүгнэлтийн (хамааралтай, донтой, аюултай хэрэглээтэй эсэх) бүртгэл судалгаа | |
| 4.17 | Амиа хорлох оролдлого хийсэн болон нас барсан хүмүүсийн мэдээлэл солилцох журам боловсруулна. | | Боловсруулсан журам | Журамгүй байсан | Журам боловсруулагдсан байна. | Амиа хорлох оролдлого хийсэн болон нас барсан хүмүүсийн мэдээлэл солилцох журмын төслийг боловсруулсан ба хянуулахаар Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | 100% |
| 4.18 | Хөдөлмөр чадвар алдалтыг тогтоох комиссын үйл ажиллагааг ээлтэй, чирэгдэлгүй зохион байгуулах | | Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлд тайлан гаргаж өгнө | Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал тогтмол зохион байгуулсан. | 2026 онд Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал тогтмол зохион байгуулна. | Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох Сэтгэцийн эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн 8 удаа хуралдаж, сунгасан 132, шинэ 81, цуцалсан 17 нийт 230 үйлчлүүлэгчид ээлжтэй, түргэн шуурхай тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 100% |
| 4.19 | Эмч нарын зөвлөгөөний комиссын хурлыг зохион байгуулах | | Хурлын протокол хөтлөж өгнө. | Эмч нарын зөвлөгөөний комиссын хурлыг зохион байгуулсан. | Эмч нарын зөвлөгөөний комиссын хурлыг зохион байгуулна. | Эмч нарын зөвлөгөөний комиссын бүрэлдэхүүн 9 удаа хуралдаж 105 үйлчлүүлэгчийн асаргааг шийдвэрлэсэн. | 100% |
| 4.20 | Үйлчлүүлэгчийг үнэгүй эмэнд шинээр оруулах хурал зохион байгуулах | | Хурлын протокол хөтлөж өгнө. | Үйлчлүүлэгчийг үнэгүй эмэнд шинээр оруулах хурал зохион байгуулсан. | Үйлчлүүлэгчийг үнэгүй эмэнд шинээр оруулах хурал зохион байгуулна. | Эмч нарын зөвлөгөөний комиссын бүрэлдэхүүн 9 удаа хуралдаж, 35 үйлчлүүлэгчид үнэгүй эм олгох зөвшөөрлийг олгосон байна. | 100% |
| 4.21 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.3 заалтын дагуу ЭМЯ, шүүх, цагдаа, прокурорын байгууллагуудаас ирсэн албан тоотын дагуу лавлагаа, | | Мэдээ тайлан нэгтгэнэ. | Мэдээ тайлан нэгтгэсэн. | Мэдээ тайлан нэгтгэсэн. | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.3 дахь заалтын дагуу эрх бүхий байгууллагаас ирсэн 173 албан бичгийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор хариу болон холбогдох материалыг хүргүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг цаг тухай бүрд хүргүүлэх | | | | | | |
| 4.22 | Япон улсын Хирошима Их Сургуулийн багтай хамтран M-speed программыг 1800-2000 мэдээлэл өгөх утсанд нэвтрүүлнэ. | | Тайлан гаргах явц боловсронгуй болно | Мэдээ тайлан нэгтгэсэн. | Мэдээ тайлан нэгтгэсэн. | Япон улсын Хирошима Их Сургуулийн багтай хамтран M-speed программыг 1800-2000 мэдээлэл өгөх утсанд нэвтрүүлж 2026 оны 6 сарын 1-ны өдрөөс эхлэн тусламж үйлчилгээнд ашиглаж эхэлсэн. | 100% |
| Зорилт 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, ажилтнуудын ёс зүйг сайжруулах, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх | | | | | | | |
| 5.1 | 2025-2028 онд хэрэгжүүлэх “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилтийн хувиар | Хөтөлбөр батлагдсан | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангаж ажиллана. |  Ёс зүй, харилцаа хандлагын сургалт (Биелэлт: 100%): * 2026 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр ЭМЯ-ны Ёс зүйн хяналтын хороотой хамтран "Ёс зүйгээр үлгэрлэсэн байгууллагын соёлыг бүрдүүлэх нь" сэдэвт сургалтыг А байрны Соёлын танхимд зохион байгуулсан.<br>Тус сургалтад СЭМҮТ-ийн удирдах түвшний менежерүүд, эмнэлгийн мэргэжилтнүүд зэрэг нийт ажилчдын 80% буюу 382 ажилтан хамрагдсан байна.<br>Урлагийн бага наадам /"Талархлын өдөр" караоке тэмцээн/ (Биелэлт: 100%):<br>Анх III улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байсан ч ажилчдын ажлын ачааллыг зохистой тайлах, багийн уур амьсгал болон дотоод харилцааг бэхжүүлэх зорилгоор I | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улиралд (3 дугаар сарын 27-нд) урагшлуулан зохион байгуулсан.<br>Бүх алба, тасаг нэгжүүд бүрэн хамрагдаж, нийт ажилчдын 70% буюу 335 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон байна.<br>Хүний нөөцийн нээлттэй мэдээллийн сан байгуулах (Биелэлт: 50%): * ХНХА-наас зохион байгуулж буй ажлуудыг тухай бүрд нь зар, мэдээллээр хүргэж ажилласан.<br>Одоогийн байдлаар дотоод группт 15 нийтлэл, цахим хуудсанд 14 журам, хөтөлбөр, ажлын байрны тодорхойлолт (АТТ) болон сул орон тооны мэдээллийг байршуулаад байна.<br>Спортын өдөрлөг (Биелэлт: 50%):<br>2026 оны 4 дүгээр сарын 09-өөс 12-ны өдрүүдэд чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр спортын 6 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулж, 250 ажилтныг хамруулсан.<br>Сар бүр төрсөн ажилчдад баяр хүргэх (Биелэлт: 49%):<br>2026 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 233 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд төрсөн өдрийн цахим мэндчилгээг тухай бүр нь хүргэж ажилласан.<br>2. Оны II хагаст хэрэгжихээр хүлээгдэж буй үйл ажиллагаа (Хэрэгжилт: 0%)<br>Дараах үйл ажиллагаанууд нь төлөвлөгөө ёсоор оны төгсгөлд зохион байгуулагдах тул эхний хагас жилд гүйцэтгэл гараагүй байна.<br>Ахмадын баяр зохион байгуулах: IV улиралд (10 сард) зохион байгуулагдана.<br>Шилдэг ажилтан шалгаруулах, алдаршуулах: IV улиралд (12 сард) зохион байгуулагдана.<br>3. Нэгдсэн дүгнэлт ба Үнэлгээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төлөвлөгөөний явц: Төлөвлөгөөт ажлууд хугацааны дагуу амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд ажилчдын бүтээмж, идэвхийг дэмжих үүднээс Урлагийн бага наадмыг хугацаанаас нь өмнө урагшлуулан зохион байгуулсан үр дүнтэй байна.<br>Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн эхний хагас жилийн дундаж биелэлт 64.1%-тай байна (Гүйцэтгэгдсэн ажлуудын дундаж хувь) | |
| 5.2 | 2025-2028 онд хэрэгжүүлэх Ажилтан, албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилтийн хувиар | Хөтөлбөр батлагдсан | 2026 онд хэрэгжүүлэх Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 70-аас доошгүй хувьд хүргэсэн байна. | 2026 онд  Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, онцгой тохиолдлын нэг удаагийн тэтгэмжийг 9 албан хаагчид олгож, нийт 10,223,400 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн өндөр насны тэтгэвэрт гарсан 1 ажилтанд 30,070,410 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон.<br><br>Сар шинийн баярыг тохиолдуулан өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад ажилтнуудад гарын бэлэг хүргүүлж, хүндэтгэл үзүүлсэн.<br><br>2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр амбулаторийн хэсэгт умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх эсийн шинжилгээг авах ажлыг “Бодь Мутар” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулсан. Тус шинжилгээнд нийт 25 ажилтан хамрагдсан.<br><br>2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 23 ажилтан төрийн болон салбарын шагнал, урамшуулал хүртсэн бөгөөд үүнээс 5 эмч, 16 сувилагч, 2 бусад ажилтан шагнагдсан байна. Үүнд:<br><br>2026 оны эхний хагас жилийн байдлаар ахмад сувилагч М.Төмөрхүү, сувилагч Ц.Гэрэлмаа, тасгийн эрхлэгч эмч Б.Энхтайван, тасгийн эрхлэгч Д. Баттөр, | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахлах шинжээч эмч Л.Баттулга нар “Алтан гадас” одон-гоор шагнагдлаа.<br><br>Мөн чанарын менежер эмч Г.Уянга, туслах сувилагч П.Вандан нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, ахмад ажилтан Д.Цэнгэлжав, Сувилахуйн албаны дарга О.Оюунтөгс нар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор, Амбулаторийн үзлэгийн эмч Г.Баярмаа нь Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан.<br><br>Мөн Сувилагчдын баярын өдрийг тохиолдуулан 9 сувилагч Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр, 3 сувилагч “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” шагнагдсан. | |
| 5.3 | 2025-2028 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, “Сургалтын хөтөлбөр”-ийг 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар | Хөтөлбөр батлагдсан | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% ханган ажиллана. | Удирдах шатны болон дунд шатны менежерүүд, ахлах сувилагч нарт зориулсан ёс зүйн манлайллын сургалт зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран зохион байгуулсан “Ёс зүйгээр үлгэрлэсэн байгууллагын соёлыг бүрдүүлэх нь” сэдэвт сургалтад нийт 53 албан тушаалтныг хамруулсан.<br>• Тус сургалтаар ажлын байран дахь ёс зүйн мэдрэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн чухал ач холбогдолтой сургалт болсон.<br>Удирдах бүрэлдэхүүн болон алба, тасгийн дарга, эрхлэгч нарт зориулсан сургалт амжилттай зохион байгуулсан.<br>Удирдлагын академитай хамтран “Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны манлайлал” сэдэвт 16 цагийн багц сургалтыг хоёр ээлжээр нийт 36 удирдах | 75% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатны болон дунд шатны менежерүүдэд зохион байгуулсан.<br>Тус сургалтаар оролцогчид орчин үеийн удирдлагын чиг хандлага, ёс зүйд суурилсан шийдвэр гаргалт, хариуцлагатай манлайллын арга барилыг эзэмшиж, байгууллагынхаа үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн чухал сургалт болсон. Үүнд:<br>← ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ: ёс зүй, ёс суртахууны зарчим, төлөвшил, ёс суртахууны манлайллыг үлгэрлэн манлайлах<br>← ЁС ЗҮЙ, ХҮНИЙ ЭРХ: ёс зүйгүй үйлдлийн ард хүний эрх зөрчигдсөн байдаг, хүний эрх зөрчигдсөн байвал ёс зүйгүй үйлдэл гарсан байдаг<br>← АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ: санаатай болон санамсаргүй байдлаар авлигын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсооход ажилтан нэг бүрийн оролцоо чухал юм.<br><br>"Гэр бүлийн үнэ цэнэ' сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Уг сургалтанд Гэр бүл судлаач, лектор Ж.Баясгалан, Хуримын ордны захирал н. Оюунзул нар хүрэлцэн ирж гэр бүлийн доторх эерэг харилцааны ач холбогдлын талаар маш сайхан мэдээлэл өгсөн үр дүнтэй сургалт болсон.<br><br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ) нь Баянзүрх дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран “Монгол өрх сэтгэлзүйн хүрээлэн” -гийн багш | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | С.Баасанбат “Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрх” сэдэвт сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 19-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Сургалтад СЭМҮТ-н 100 орчим эмч, сувилагч, бусад мэргэжилтнүүд хамрагдсан. | |
| 5.4 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль, журам, стандартын хүрээнд хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилтийн хувь | 30% | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг 50%-аас дээш хувьд хүргэж ажиллана. | • Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлах -100%<br>• Жилийн гүйцэтгэлийн ажлын төлөвлөгөө батлуулах 100%<br>• Анхан болон давтан хэвтэлтийн өвчний түүх 5622 ширхэгийг архивласан /100%/<br>• Шүүх цагдаагийн албан тоот 223 ширхэг ирсэнээс 114 ширхэг өвчний түүх хуулбарлан өгсөн. /100%/<br>• Эмч нарын өвчний түүх захиалга 171 ширхэгийг гарган өгч буцаан авч байршуулсан 100%<br>• Ажилчдын өргөдөл 5 ширхэгийг шийдвэрлэсэн /тушаал болон ээлжийн амралт/ 100%<br>• Иргэдийн 3 ширхэг өргөдөлийн хариуг өгсөн. 100%<br>• 2025 оны хадгаламжийн нэгж 253 ширхэг хүлээн авсан. /зарим нэгжүүд дутуу/ 60%<br>• Баримтын цэгцлэлт 40% тай байна./багтаамж дүүрсэн<br>• 2016-2023 он хүртэлх байнга,түр ,70 жилийн баримтын бүртгэл дууссан 100%<br>• 2024-2025оны баримтын бүртгэл дутуу 40%<br>Хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөө тогтмол үйл ажиллагааны биелэлт 100%<br>Нэмэлт гүйцэтгэл буюу архив цэгцлэхтэй холбоотой биелэлт 40% байна. | 70% |

<table>
<tr><td>5.5</td><td>Өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх</td><td></td><td>Шийдвэрлэлтийн хувь</td><td>80 хувь</td><td>Өргөдөл, санал, гомдлыг хуулийн хүрээнд цаг хугацаанд нь шийдвэрлэнэ.</td><td><table><tr><td>Ажилчид</td><td>Өргөдөл</td><td>Хүсэлт</td><td>Санал</td><td>Гомдол</td><td>Шийдсэн</td><td>Хугацаа болоогүй</td></tr><tr><td>Нийт-220</td><td>134</td><td>85</td><td>1</td><td>0</td><td>196</td><td>24</td></tr></table><table><tr><td>Иргэд</td><td>Өргөдөл</td><td>Хүсэлт</td><td>Санал</td><td>Гомдол</td><td>Шийдсэн</td><td>Хугацаа болоогүй</td><td>11:11</td></tr><tr><td>Нийт-91</td><td>41</td><td>42</td><td>0</td><td>8</td><td>80</td><td>11</td><td>73</td></tr></table>Эхний хагас жилийн байдлаар нийт 311 өргөдөл ирсний 220 нь ажилтнаас, 91 иргэдийн өргөдөл байсан. Өргөдлийн төрөл, шийдвэрлэсэн байдлыг дээрх хүснэгтээр үзүүлэв.</td><td>75%</td></tr>
<tr><td>5.6</td><td>Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, дархлаажуулах, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>Арга хэмжээний тоо<br>Хамрагдсан ажилчдын тоо</td><td>93,1 хувь</td><td>Бүх ажилчдыг хамруулан ажиллана.</td><td>2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр амбулаторийн хэсэгт умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх эсийн шинжилгээг авах ажлыг “Бодь Мутар” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулсан. Тус шинжилгээнд нийт 25 ажилтан хамрагдсан.</td><td>50%</td></tr>
<tr><td>5.7</td><td>Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр боловсруулах</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>Арга хэмжээний тоо<br>Хамрагдсан ажилчдын тоо</td><td>Байхгүй</td><td>Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжилтийг хэрэгжүүлэн ажиллана.</td><td>2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 41 шинэ ажилтныг хөтөлбөрийн дагуу “Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтанд хамрууллаа.</td><td>100%</td></tr>
<tr><td>5.8</td><td>ХНУМТ-ийн системийн мэдээлиийн санг шинэчлэн бүртгэх, ABLE программын хэрэглээг хэвшүүлэх</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>Шийдвэрлэсэн бичиг баримтын тоо</td><td>Өдөр тутам хэрэглэгддэг</td><td>ХНУМТ-ийн систем, Able программд орсон гарсан хөдөлгөөнийг цаг тухай бүрд бүртгэн ажиллана.</td><td>2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Захирлын А/01 дүгээр тушаалыг үндэслэн байгууллагын нийт хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний өөрчлөлт, шинэчлэлтийг системд бүрэн оруулж гүйцэтгэсэн.<br>Цалингийн шатлал, нэмэгдлийн шинэчлэлт:<br>2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоол болон Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/11 тоот тушаалын дагуу төвийн нийт ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдлийг тооцон мэдээллийн санд шинэчлэн оруулсан.<br>Мөн оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн газрын 135 дугаар тогтоол</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсантай холбогдуулан нийт ажилчдын (479) цалингийн өөрчлөлтийг нэг бүрчлэн дахин хянаж, системд тухай бүр үнэн зөвөөр шинэчлэн суулгаж ажиллалаа.<br>2.Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем (ХНУМТ) болон байгууллагын дотоод ABLE программын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд ажилчдын хөдөлгөөний төлөвийг цаг тухай бүрд нь өөрчилж, өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэв. Үүнд:<br>Шинээр ажилд орсон: Нийт 29 шинэ ажилтныг системд шинээр бүртгэж, хувийн хэрэг болон эрх үүсгэх ажлыг бүрэн хийсэн.<br>Ажлаас чөлөөлөгдсөн болон сэлгэсэн: Байгууллагаас гарсан болон сэлгэн ажилласан нийт 24 ажилтны төлөвийг идэвхгүй болгож, хөдөлгөөнийг баталгаажуулсан.<br>Жирэмсний болон амаржсаны амралт: Хүүхэд асрах болон жирэмсний амралттай байгаа нийт 47 ажилтнаас тухайн хугацаанд тус амралтыг шинээр авсан 5 ажилтны төлөвийн өөрчлөлтийг оруулсан.<br>Ажилдаа эргэн орсон: Жирэмсний болон хүүхэд асрах амралтаас ажилдаа эргэн орсон 7 ажилтныг үндсэн ажилчны төлөвт шилжүүлж, цаг бүртгэлийн системд идэвхжүүллээ.<br>Мөн өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, жижүүр эмч, гадуур ажилтай, сургалттай, томилолт гэх мэт төлөвийн хүсэлтийг цаг тухай бүрд хүлээн авран баталгаажуулан ажилласан. Нийт 140 тушаалын төсөл боловсруулан захирлаар баталгаажуулсан. Тус албанд хагас жилийн байдлаар ажилчдаас 119 өргөдөл ирснийг хууль журмын дагуу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэн ажилласан байна. ЭМЯ болон бусад байгууллагаас 14 албан бичгийн хариуг төлөвлөн хүргүүлсэн байна. | |
| Зорилт 6: Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах | | | | | | | |
| 6.1 | 2026 оны тусламж, үйлчилгээний хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцоолон, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллана. | - | ЭМДЕГ-аас сонгон шалгаруулалтын дагуу байгуулсан гэрээ | 2025 онд ЭМДЕГ-тай гэрээ байгуулан, тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцоолон, биелүүлэн ажиллана | 2026 оны эхний хасаг жилийн байдлаар ЭМДЕГ-тай 6,142,308,875.28 төгрөгийн гэрээ байгуулж 7,140,413,514.00 төгрөгийн гүйцэтгэлийг ЭМДС-гаас нэхэмжилсэн ба үүнээс 170,443,765 төгрөгийн хасагдал үүсч 97,8% гүйцэтгэлтэйгээр ажилласан. | 90% |
| 6.2 | Төвийн мэдээллийн технологийн аюулгүй байдлын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд ажиллах | - | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлсэн тоо | Холбогдох журам, тушаалаар батлагдсан байна. | Батлагдсан журмын дагуу сургалт, танилцуулга хийгдсэн байна. | 2026.4 сараас -2026.11 сар хүртэлх Эрүүл мэндийн салбар дахь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх сургалтад хамрагдаж мэдээлэл мэргэшлээр хангагдаж ажиллаж байна. | 75% |
| 6.3 | Төвийн хяналтын камерын хэвийн ажиллагаа, шинэчлэлт, хяналтыг сайжруулах. | | Төвийн хэмжээнд хяналтын камер шинээр байршуулж үйл ажиллагаанд оруулсан тоо | Камерын хүрэлцээ хангалтгүй | Тасаг нэгжид хяналтын системээр шинэчлэгдэж хяналт сайжирсан байна | Хүний Эрхийн Комиссын зөвлөмжийн дагуу сохор цэгт бэлэн байсан болон зарим нөөц 2 камеруудыг суурьлуулсан. Энэ оны 5-р сард хяналтын камерын тендер зарлагдаж<br>● дотор камер-25<br>● гадна камер-4<br>● NVR-4<br>● TV-4<br>● Хайрцаг-13<br>Тус тус авснаас 22 дотор камер, 3 NVR, 3 TV, 9 хайрцаг суурьлуулсан. Тохиргооны ажил хийгдэж байна. | 75% |
| 6.4 | Төвийн хэмжээнд албаны дотоод удирдлагын систем нэвтрүүлж, үйл ажиллагааг нэгдсэн | | Төвийн хэмжээнд нэвтрүүлсэн удирдлагын | Нэгдсэн удирдлагын системд шилжин үндсэн 30 эрхтэй. | Алба нэгжийн цахим нэгдсэн удирдлагаар хангаж, албан бичиг,цаг бүртгэл, | Дотоод албан бичиг, цаг бүртгэлийн талаар заавар өгч, мөн Эйблсофт-той холбогдож хөгжүүлэлт, зарим шинэчлэлтийн алдаануудыг засуулахаар ажиллаж байна. Мөн дэд | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим удирдлагаар хангах | | системийн модулийн тоо | | ажил хэрэг модулиуд нэвтрүүлэн нийт үндсэн 65 эрхээр үйл ажиллагааг цахимжуулсан байна | эрх буюу утсаар цаг бүртгүүлэх 53 эрхийн хэрхэн ашиглах заавар өгч байна. | |
| 6.5 | Цахим хуудсыг шинэчлэн сайжруулах | | Цахим хуудасыг шинэчлэн, нээлттэй мэдээлэл оруулж shilen.gov.mn сайтаас гарсан улирлын тайлангын үнэлгээ | Цахим хуудас программын ашиглалтын хугацаа дууссан шинэчлэх шаардлагатай. | цахим хуудсыг шинэчлэн сайжруулж,"shilen.gov.mn" нээлттэй мэдээллийн цахим системийн үнэлгээ сайжирсан байна. | -Төвийн хэмжээнд цахим Веб хуудсыг шинээр хийж 2026.03-06 сарын хооронд 42 мэдээ оруулсан.<br>- shilen.gov.mn мэдээллийг цаг тухай бүрдэн бүртгэж эхний улирлын дүнгээр 92,86% дүгнэгдэж ажилласан. | 100% |
| 6.6 | Төвийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, тавигдах нийтлэг шаардлага, техник хэрэгсэл шинэчлэн засвар үйлчилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг сайжруулах | | Төвийн хэмжээнд тоног төхөөрөмж шинэчлэн сайжруулсан тоо | Хэрэгцээтэй байгаа 50 ширхэг комьютер принтер 10 ширхэг дутагдалтай байна. | Дутагдалтай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг авч хэрэгцээ шаардлага сайжирсан байна.. | Шинээр компьютер болон принтер худалдан авах тендер төлөвлөгөөнд тусгагдан ажиллаж байна | 25% |
| 6.7 | Төвийн дотоод хяналтыг сайжруулах | | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар | Дотоод хяналт хийх төлөвлөгөө батлагдсан байна | Төлевлгөөний дагуу хяналт хийгдсэн байна | Төвийн захирлын 2026.01.13-ны өдрийн "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/05 тоот тушаал, мөн 2026.01.13-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/04 тоот тушаалаар телекамерын хяналтын журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Төвийн хэмжээнд 2026 онд алба, тасаг нэгжүүдэд дотоод хяналт, шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөө гарган батлуулж , хуваарьт дотоод хяналт шалгалтыг тухай бүр батлагдсан удирдамжтайгаар хийж, шалгалтын тайланг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 7: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | | | | | | | |
| 7.1 | Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөнд тодотгол хийж шинэчлэн баталж хэрэгжүүлнэ. | | | 2025 онд Гамшгийн нөхцөл байдалтай холбоотойгоор 1-3 сарын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажилласан. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. 1-3 сарын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажилласан байна. | Гамшгийн үеийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг 2026 оны 05 сарын 11-нд шинэчлэн боловсруулж батлуулсан. 2026 оны 05 сарын 13-15 –ны хооронд Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар хамтран зохион байгуулсан “Гамшгийн үеийн бэлэн байдлын команд штаб”-ын сургалтанд амжилттай хамрагдсан. | 100% |
| 7.2 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зуд гамшгийн үед сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулна. | | Сургалтад хамрагдсан хүний тоо | 2025 онд 98 хүнд сургалтыг зохион байгуулсан. | Аймаг, дүүргийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, онцгой байдлын 100 албан хаагч нарт сургалт хийсэн байна. | 1. ОБЕГ-ын 40 сэтгэл зүйчдэд 2026 оны 06 сарын 03-ны өдөр "нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тусламж үйлчилгээ" сэдвээр 2 удаагийн сургалт явуулсан. 2. СЭМҮТ нь НТТТ-ийн нийт 152 эмч нарт богино хугацаанд анхны эмнэл зүйн үнэлгээ хийх, үйлчлүүлэгчийн болон орчны аюулгүй байдлыг хангах, зан төрхийн өөрчлөлтийг тогтворжуулах, цаашдын эмчилгээний шийдвэрийг шуурхай гаргах ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 06-наас 17-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулсан. | 100% |
| 7.3 | Галын аюулгүй байдлын сургалтыг БЗД-ийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулна. | | | 2024 онд сургалт хийгдсэн. | Сургалт зохион байгуулагдсан байна. | Галын аюулгүй байдлын сургалтыг БЗД-ийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. | 30% |

*Төлөвлөгөөг хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

....................... ......................... /................................./

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**

............................. ......................... /................................./

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................